



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/509

Мандалговь

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн
улсын тооллогын салбар комисс байгуулах тухай

Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам"-ын 2.2, 2.4 дэх заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/648 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн нийт нутаг дэвсгэрт харьяалах төрийн болон орон нутгийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогын салбар комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Ц.Бумангэрэл	Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
Гишүүд: Ц.Даваа	Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, хяналт хариуцсан мэргэжилтэн
Л.Ганбат	Мэргэжлийн хяналтын газрын боловсрол, соёлын хяналтын улсын байцаагч
М.Бямбажав	Музейн захирал
Б.Рашинхүү	Музейн сан хөмрөгийн эрхлэгч
Ш.Цэрэндаш	Музейн харуул

Нарийн бичгийн дарга: Ж.Мөнхцэцэг Музейн бүртгэл мэдээллийн санч
Хоёр. Улсын тооллогыг удирдамжийн дагуу үр дүнтэй зохион байгуулж, нэгдсэн дүн, тайлан мэдээг улсын комисст хугацаанд нь хүргүүлэхийг салбар комисс /Ц.Бумангэрэл/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

438010584